

Nissui групп хүний эрхийн бодлого

Nissui групп нь далайн нөөцийг тогтвортой байдлаар ашиглах болон дэлхийн байгаль орчныг хамгаалахад анхаарч, байгалийн баялагаас олон төрлийн үнэ цэнийг бий болгож эрүүл, сайхан амтыг дэлхийн өнцөг булан бүрт байгаа хүмүүст хүргэдэг. Манай бизнестэй холбоотой бүх ханган нийлүүлэлтийн сүлжээнд хүний эрхийг дээдлэх нь нэн тэргүүний зорилт бөгөөд энэ үүрэг хар иуцлагыг биелүүлэхийн тулд хичээнгүйлэн ажилладаг.

Хүний эрхийг дээдлэх

Nissui групп нь “Олон улсын хүний эрхийн билль” болон Олон улсын хөдөлмөрийн байгууллагын (ОУХБ) “Хөдөлмөрийн үндсэн зарчим ба эрхийн тухай тунхаглал (тэмдэглэл)”-д тусгагдсан хүний эрхийг дээдэлдэг бөгөөд “Бизнес ба хүний эрхийн талаарх НҮБ-ын чиглүүлэх зарчмууд”-д тулгуурлан практикт хэрэгжүүлэх тал дээр анхаарч ажилладаг. Түүнчлэн Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хүний эрх болон улс, бүс нутаг бүрийн хууль тогтоомжийн хооронд ялгаа байх бөгөөд хэрэв зөрчил гарсан тохиолдолд бид олон улсын хүний эрхийн зарчмуудыг хүндэтгэх арга замыг эрэлхийлэх болно.

Бодлогын хамрах хүрээ

Энэхүү бодлого нь Nissui Corporation болон түүний групп компаниудын бүх үдирдлагууд, ажилтнуудад хамаарна. Мөн Nissui группын бизнесийн түншүүд, тэр дундаа ханган нийлүүлэгчид энэхүү бодлогыг хүндэтгэж, хүний эрхийг дээдлэх үүрэгтэй.

Хүний эрхийн зохих шалгалт

Nissui групп нь бизнесийн үйл ажиллагааныхаа хүрээнд хүний эрхийн болзошгүй болон одоо байгаа эрсдэлүүдийг тодорхойлж, тэдгээр эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бууруулах механизмыг бий болгож, тасралтгүй хэрэгжүүлнэ.

Боловсрол

Nissui групп нь бизнесийн үйл ажиллагаагаар дамжуулан энэхүү бодлогыг үрдүнтэй хэрэгжүүлэхийн тулд удирдах албан тушаалтнууд, ажилтануудаа тогтмол сургалтанд хамруулж мэдлэг олгох болно.

Оролцогч талуудтай яриа хэлэлцээ хийх

Nissui групп нь хүний эрхэд учирч болзошгүй болон одоо байгаа сөрөг нөлөөллийн талаарх арга хэмжээг авч үзэхийн тулд холбогдох талуудтай яриа хэлэлцээ хийж, зөвлөлдөх болно.

Туслалцаа

Хэрэв Nissui группын бизнесийн үйл ажиллагаа нь хүний эрхэд сөрөг нөлөө үзүүлсэн эсвэл нөлөөлсөн нь тогтоогдвол нөхцөл байдлыг засахын тулд зохих арга хэмжээг авах болно.

Мэдээллийн ил тод байдал

Nissui Corporation нь энэхүү бодлогод үндэслэн хүний эрхийг хүндэтгэх хүчин чармайлтын талаарх мэдээллийг цахим хуудас болон бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтлэх болно.

Системийн хөгжил

Nissui групп нь энэхүү бодлогыг хэрэгжүүлэх үүрэгтэй хувь хүнийг томилж, хүний эрхийг дээдэлсэн бизнесийн үйл ажиллагааг дэмжих тогтолцоог бий болгоно.

Хүчин төгөлдөр болсон огноо: 2020 оны 9-р сарын 10-ны өдөр
(тэмдэглэл: Албадан хөдөлмөр эрхлэлтийг хориглох, хүүхдийн хөдөлмөрийг халах тухай зүйлүүдийг багтаасан болно.)